

# Библийг хөрвүүлэх найман дүрэм.

“Бид илүү баттай болгогдсон эш үзүүлэгийн үгтэй. Үүр цайж, үүрийн цолмон зүрхэнд тань гийх хүртэл, харанхуй газарт гэрэлтэж буй дэнлүүг анхаарах мэт та нар түүнд анхаарал тавихдаа сайн байдаг. Судрын нэг ч эш үзүүлэг эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн.” ~ 2 Петр 1:19-20

“Мэргэн нэгэн нь сонсож, мэдлэгээ тэлэх, Ухаалаг нэгэн нь мэргэн зөвлөгөөг авахын тулд; Сургаалт үгс хийгээд сургаалт зүйрлэлүүд ба Мэргэн ухаантнуудын үгс хийгээд оньсого таавруудыг нь ухааж ойлгохын тулд юм.” ~ Сургаалт үгс 1:5-6.

Ариун Библи нь Ариун Сүнсээр хөтлөгдөж удирдуулсан хүмүүсээр бичигдсэн юм. Бурхан гайхамшигтайгаар эдгээр бичээсүүдийг нэг ном болгон нэгтгэн Ариун Библийг бүтээсэн. Үүгээр дамжуулан Бурхан бидэнд өөрийгөө таниулах, мөн өөрийнхөө замыг заахыг хүсдэг. Библи нь нууцууд, илчлэлтээр дүүрэн ном бөгөөд бид Бурхан дотор өсөхдөө тэдгээрийг улам ихээр таниж мэддэг билээ.

Библийг уншаад ойлгохгүй байсан ч бүү шантраарай. Бурхан бидэнд хайртай учраас бидэнд зааж өөрийгөө бидэнд таниулах болно.

Дараах хэдэн чухал зүйлсийг бид санаж байх хэрэгтэй:

1. Бид Түүний Сүнсээр дахин төрсөн байх
2. Бид Библи нь Бурханы эрх мэдэлтэй үг бөгөөд, ганхашгүй, Түүнээс ирсэн гэдэгт итгэх
3. Бид Библийн ишлэлийг уншихдаа Бурханы Ариун Сүнс бидэнд үнэнийг тайлж өгнө гэдэгт найдах
4. Бид Бурханы өмнө даруу, суралцах зүрх сэтгэлээр ирэх
5. Бид Библийг зүгээр унших биш судлах хэрэгтэй
6. Бид, Бурхан бидэнд өөрийгөө нэг мөсөн таниулах бус, алхам алхамаар таниулж өсгөдөг гэдэгт итгэх
7. Бид Библийн орчуулгүүдыг харицуулан унших хэрэгтэй. Зарим хувилбарууд нь илүү зөв, мөн сүнслэг байдаг.

Дараах 8 дүрэм нь хэлзүй, дүрмийн орчуулгын амин зүрх нь бөгөөд эрдэмтэдээр хүлээн зөвшөөрөгдөж одоог хүртэл хэрэглэгдэж байгаа юм (8-р дүрмээс бусад, 8-р дүрэм нь Библийн орчуулганд зориулагдсан болно). Эдгээр 8 дүрэм нь Ариун Библийг хөрвүүлэхэд үргэлж ашиглагдаж байх ёстой.

Бурхан үл ойлголцол, төөрөгдлийг бий болгогч биш бөгөөд (1 Кор. 14:33), Христ итгэлт хүмүүсийн дунд цөөнгүй маргаан байдаг хэдий ч, Эзэн биднийг даруу, Есүсийн үгэнд итгэх үед бидэнд замыг харуулдаг. “Үнэний Сүнс та нарыг бүх үнэнрүү хөтлөх болно” (Иохан 16:13). Эдгээр 8 дүрэм нь Библийн ишлэлүүдийг зөвөөр ойлгоход туслах болно. Библийг ойлгох нь хэсэг дүрмийг ойлгож мэдэхээс илүүтэй хөрвүүлж ойлгох чадварыг шаарддаг. Дүрэм нь бидний оюун бодлыг дасгалжуулж Библийг өөрсдийн хүссэнээр ойлгох биш, Библийн жинхэнэ утгыг ойлгоход туслах юм.

## Найман дүрэм

### 1. Утгыг тайлбарлах

**Библийн (багц) ишлэл, үгийг (үгийг утгачлах) тодорхойлох, (үндсэн утга санааг) тогтсон утгыг нь дагаж мөрдөх.**

Үг гэж юу вэ? Бичээсийг судлах нь үгийг судлахаас эхэлдэг. Үгийн утга, хэллэгийг тодорхойлох. Орчуулагч нь үгийн тодорхой утгыг гаргаж байх хэрэгтэй. Зарим тохиолдолд Еврэй-Англи, Грек-Англи толь бичгийг ашиглан үл ойлгогдох, тодорхойгүй утгуудыг тодорхой болгох нь зүйтэй. Эдгээрийг ашиглахад заавал Библи Судлаач байх шаардлагагүй!!

### 2. Хам сэдэвтэй харицуулах

**Ишлэлийг орчуулахдаа хам сэдэвтэй нь уялдуулан орчуулах.**

Хам сэдэв гэдэг нь тухайн ишлэл агуулагдаж буй бүлэг бичээсийг хэлж буй юм. Утга нь энэ хам сэдэвээс харагдаж байх ёстой. Энэ нь таны уншиж буй үг бүр өмнөх, хойдох ишлэлтэйгээ утгын хувьд уялдаж байх шаардлагатай. Бусад олон ишлэлүүд хам сэдэвийг нь (хам сэдэвтэй нь холбон) ойлгож байж үнэн зөвөөр ойлгогддог.

### 3. Тухайн цаг үе түүх, соёлын хүрээнд (хүрч) ойлгох

#### Орчуулгыг түүхийн (нөхцөлөөс) судалгаанаас бүү салгаарай

Бид тухайн бичээс бичигдсэн цаг үе, нийгэм, соёлын нөхцөл байдлыг мэдэж байх хэрэгтэй байдаг. Үүнгүйгээр Библи дэх сүнслэг зарчимуудыг (бүрэн эхээр нь) бүтнээр нь ойлгоход хязгаарлагдмал байдаг. Бид өөрсдийн амьдарж буй нийгэм соёлын ойлголтон дээр тулгуурлан үгийг орчуулах нь учир дутагдалтай болно. Бичээсийг бичсэн хүмүүсийн тухайн үед бичиж байсан цаг үеийг ойлгож унших нь бидэнд ойлгоход илүү дөхөм болдог.

### 4. Логик дүрэм

#### Орчуулж буй үгнүүд нь ерөнхий нөхцөлтэй нэгдэж байх хэрэгтэй.

Логик нь бүх төрлийн мэдлэг, судалгаанд ашиглагддаг зарчим юм. Орчуулах, хөрвүүлэх нь логик эргэцүүлэл юм. Логик нь Бурханы болоод итгэлийн эсрэг зүйл биш билээ. Бурхан хэлэхдээ : "Нааш ир. Хамт хэлэлцье" гэж ЭЗЭН айлдаж байна. Исаиа 1:18. Бид Библийг хөрвүүлж байхдаа энэ утга нь зөвүү гэж өөрсдөөсөө асууж байх хэрэгтэй. Бид бусад зүйлсийг орчуулхад хэрэглэдэг хэлзүй, дүрмийн анализийг ашиглах н зохистой юм. Логик, мөн баримт нь буруу теологийн хөрвүүлэг, тодорхой бус нөхцөлөөс сэргийлэх юм.

### 5. Тогтсон жишиг

#### Хэрэглэж тогтсон үгийн утгыг хэрэглэх, тодорхойгүй бүдэг утгыг хэрэглэхгүй байх

Өнгөрсөнд ашиглагдаж хэвшсэн зүйлс нь жишиг болсон байдаг. Хэв.сэн ойлголтыг өөр үгээр орлуулах нь зохисгүй. Шүүгч нь өмнөх хэргүүдэд яаж шийдэж байсантай харицуулж хардаг шиг, Биглийг тайлахдаа мөн адил хийх нь зөв юм. Үйлс 17:10-12 дээр гардагчлан, Берианчууд Паулын заасныг бичээснээс хайж тулгасан байдаг. Мөн 2 Тимот 2:15 дээр “Чи өөрийгөө ичих явдалгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээгтүн” гэсэн байдаг.

### 6. Зохицон уялдах дүрэм

#### Ишлэл бүр бусад ишлэлтэй зохицон хөрвүүлэгдэх ёстой.

Библи нь Бурханы, нэг оюун бодлын бүтээл. Тиймээс бичээс нь бичээстэйгээ зөрчилдөх ёсгүй. Үнэнд олон тал байдаг. Ишлэл бүр нь үнэн хэдий ч бүх үнэнийг илэрхийлдэггүй. Ихэвчлэн ишлэлүүд нь онцгой үнэнийг хэлэх зорилготой байдаг. Бид тухайн сэдвийн олон ишлэлийг цуглуулан харьцуулсаны эцэст нэгдсэн дүгнэлт гаргах хэрэгтэй.

### 7. Дүгнэх

#### Дүгнэлтийг урьдны факт, баримт дээр тулгуурлан гаргах нь зохистой.

Энэ логик гаргалгаагаар, факт, нөхцөл дээр үндэслэн гаргасан дүгнэлт гаргах юм. Тухайн факт эсвэл таамаглал, нь үнэн болон батлагдхад хангалттай нотлох баримт, нотолгоо хэрэгтэй.

### 8. Шинэ Гэрээн дэх Христийн үйлдсэн (хийсэн) ажлууд, түүнтэй харьцуулах

#### Шинэ Гэрээ, Хуучин Гэрээний уялдаа холбоо, мөн ялгаатай байдлыг үргэлж санаж байх.

Бид анхлан Библи уншихад Шинэ Гэрээ болон Хуучин Гэрээний номнууд үнэхээр их ялгаатайг олж хардаг. Энэхүү ялгаанууд нь хоорондоо зөрчилдөж буй мэт санагдах нь олонтаа. Бурхан өөрийгөө хүмүүст таниулахдаа алхам алхамаар таниулдаг. Тэр нэг удаадаа өөрийгөө бүрэн бүтнээр нь илчилдэггүй, цагын аясаар аажимдаа таниулдаг. Хуучин Гэрээн дээр Тэр олон зүйлийг харуулсан. Тэгээд Есүс ирсэн! Бид “1 Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олон хэсгээр болон янз бүрийн арга замаар айлдсан Бурхан 2 эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. Тэр Хүүгээ бүхний өвлөгчөөр томилсон бөгөөд Хүүгээрээ ертөнцийг бүтээсэн билээ.” гэж уншсан билээ.

*“Шинэ нь хуучинд нууцлагдаж хуучин нь шинэд илчлэгддэг”*

Энэ ухаалаг бөгөөд энгийн үгийг бидэнд Августин Шинэ Гэрээ, Хуучин Гэрээний харилцан уялдааг ойлгоход дөхөм болгон бичиж үлдээсэн байдаг. Хуучин Гэрээ нь юмсыг урьдчилан харж Бурханы хүмүүсийг Шинэ Гэрээн дэх Христийн ажилд бэлдсэн байдаг. Есүс бидэнд Ариун Сүнсэн доторх шинэ амьдралыг өгхөөр ирсэн нь Хуучин Гэрээний хүмүүсийн аж амьдралаас тэс ондоо юм. Тэгэхээр бид одооноос бичээсийг уншихдаа энэ өнцөгөөс ойлгож байх хэрэгтэй. Еврей ном нь Бурхан хэрхэн бидэнтэй Өөрийн Хүүгээр дамжуулан ярьж байгааг ойлгоход туслах ном юм.